

БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.БАТСАЙХАН

8128921 1197149641

МОНГОЛ УЛСЫН ӨНДРИЙН 1 ДҮГЭЭР АНГИЙН СҮЛЖЭЭНИЙ 2 ДУГААР
ГАРЫН ТЭГШИТГЭН БОДОЛТЫГ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 03 дугаар сарын 13 өдөр

Дугаар ...

AD
2023-04

Улаанбаатар хот

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажлын үндэслэл	1. Геодези, зураг зүйн тухай хууль, 2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол /Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай/, 3. ГХГЗЗГ-ын даргын 2014 оны А/261 дугаар тушаал /Геоидын өндрийн загвар батлах тухай/, 4. ГЗБГЗЗГ-ын стратеги төлөвлөгөөний зорилт 1.4.1, 5. ГЗБГЗЗГ-ын 2023 оны “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө”.
2.	Ажлын зорилго	Монгол Улсын өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний хэмжилтийн үр дүнг тэгшитгэн бодно.
3.	Хамрах хүрээ	Архангай, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Өвөрхангай аймаг
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Ажил гүйцэтгэх гэрээ баталгаажсан өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүртэл
5.	Гүйцэтгэх ажлын хэмжээ	8 шугам, 2 полигон, 541 цэг /тэгшитгэн бодолт хийх 7 цэгийн өгөгдлийг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс хойш хүлээн авна/
6.	Ажлын иж бүрдэл	1. Өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг тэгшитгэн бодох: 8 шугамыг тус бүрд нь тэгшитгэн бодно. 1-р полигон, 2-р полигоныг тэгшитгэн бодно. 2 полигоныг нэгтгэн тэгшитгэн бодно. 2. Гравиметрийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг тэгшитгэх: 491 цэгийн гравиметрийн сүлжээний өгөгдлийг тэгшитгэн бодно. 3. Цэгийн жагсаалт гаргах: Өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын үр дүн, гравиметрийн сүлжээний тэгшитгэн бодолтын үр дүнгийн жагсаалтыг бэлтгэнэ.
7.	Ажлын үр дүн	Өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний 8 шугам, 2 полигоны тэгшитгэн бодсон өндрийн жагсаалт, хүндийн хүчний хурдатгалын жагсаалт гаргана.
8.	Техникийн шаардлага	- “Өндрийн 1, 2 дугаар ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын ажил” /БД 11-107-16/ барилгын дүрэм,

		<ul style="list-style-type: none"> - “Монгол Улсын гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах үндсэн дүрэм” /БНБД 11-10-17/ барилгын норм ба дүрэм, - Өндрийн болон гравиметрийн сүлжээний тэгшитгэн бодолтын программ хангамж.
9.	Хяналт, шалгалт	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Геодези, зураг зүйн хэлтэс, Газрын даргын 2022 оны А/194 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам”-ыг баримтална.
10.	Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> - Сүлжээний боловсруулалт, тэгшитгэн бодолтын ажлын тайлан /тоон болон хэвлэмэл байдлаар/ - Өндөр, гравиметрийн сүлжээний тэгшитгэн бодолтын үр дүн каталоги /тоон болон хэвлэмэл байдлаар/ - Дээрх материалуудыг тоон байдлаар 3% /DVD/, хэвлэмэл байдлаар- 1% хүлээлгэн өгнө.
11.	Захиалагч байгууллага	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
12.	Гүйцэтгэгч байгууллага	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд /Геодезийн зөвлөх эсхүл мэргэшсэн инженертэй байх/
13.	Хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсгэвэр	Урсгал төсөв - 15 сая төгрөг.
14.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.